	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,490,568.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,490,568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,490,568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,490,568.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,511,668.00
210402	Тээвэр, шатахуун	3,511,668.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,978,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,978,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,490,568.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,490,568.00

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,490,568.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Ногооннуур сумын Засаг дарга нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “Хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, аймгийн Загвар сум болгох” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.Үүнд:

- Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх
- Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах
- Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах.
- Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2024 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 280.3 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	265,905.5	504,299.4	238,393.8
Авлага	202,985.2	172,723.0	-30,262.2
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	86,811.5	106,853.8	20,042.2
Үндсэн хөрөнгө	3,999,443.5	4,051,596.1	52,152.6
Нийт хөрөнгө	<u>4,555,145.7</u>	<u>4,835,472.2</u>	<u>280,326.5</u>
Өр төлбөр	43,638.5	41,109.6	-2,528.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,511,507.2	4,794,362.6	282,855.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>4,555,145.7</u>	<u>4,835,472.2</u>	<u>280,326.5</u>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 504,299.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 238,393.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	265,905.5	504,299.4	238,393.8
Төгрөг	265,905.5	504,299.4	238,963.4
Төрийн сангийн харилцах	260,642.7	498,821.3	238,178.6
Арилжааны банк дахь харилцах	5,262.9	5,478.1	215.2
Дүн	265,905.6	504,299.4	238,393.8

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Оны эцэст Төсвийн ерөнхий орлогын дансанд 164,392.5 мянган төгрөг, ОНХСанд 226,942.4 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн дансанд 107,486.4 мянган төгрөг, эргэлтийн эмийн сан 5,478.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 172,722.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 30,262.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	625.1	9,046.9	8,421.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	613.2	-	613.2
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
Зээлийн авлага	201,746.9	163,676.0	-38,070.9
Хувь хүмүүст олгосон зээл	201,746.9	163,676.0	-38,070.9
Дүн	202,985,2	172,722.9	30,262.3

сурвалж: Аудитын судалгаа

Ажиллагсадтай холбоотой авлага 8,421.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 38,070.9 мянган төгрөгөөр буурсан байна.

- Аудитын илрүүлэлт: Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 106,853.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 20,042.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	13,968.7	13,263.1	705,6
Эм боох материал	13,968.7	13,263.1	705,6
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
Хангамжийн материал	52,742.8	73,490.7	20,747.9
Бичиг хэргийн материал	-	-	0
Аж ахуйн материал	30,240.2	50,649.7	20,409.5
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	5,837.9	6,176.2	338,3
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	16,664.8	16,664.8	0.0
Мал амьтад	20,100.0	20,100.0	0.0
Дүн	86,811.5	106,853.8	20,042.3

Эх сурвалж: Аудитын судалгаа

ЗДТГ 92,075.2 мянган төгрөгийн, ИТХ 1,515.0 мянган төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 13,263.1 мянган төгрөгийн нийтдээ 106,853.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

- **Аудитын илрүүлэлт:** Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгө байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,051,596.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 52,152.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3.992,443.5	4.044,168.3	51,724.8
Барилга, байгууламж, орон сууц	659,629.6	765,886.6	106,257.0
Авто-тээврийн хэрэгсэл	131,888.5	350,912.3	219,023.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	98,116.6	122,406.0	24,289.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	35,917.5	35,482.2	(435.3)
Зам, гүүрийн байгууламж	3,065,302.2	2,767,847.5	(297,454.7)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
Дуусаагүй барилга, байгууламж	-	-	0
Ном	1,633.6	1,633.6	0
Биет бус хөрөнгө	6,955.2	7,427.8	472.6
Программ хангамж	1,423.2	1,895.8	472.6
Бусад биет бус хөрөнгө	5,532.0	5,532.0	0
Дүн	3,999,443.4	4,051,596.1	52,152.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 3,999,443.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба 9,420.0 мянган төгрөгийн хөрөнгийн худалдан авч, 463,286.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 407,208.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулж оны эцэст 4,051,596.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

- Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данс оны эцэст 41,106.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 2,531.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	43,638.5	41,106.6	2,531.9
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Бусад өглөг	43,638.5	41,106.6	2,531.9
Байгууллагад төлөх өглөг	43,638.5	41,106.6	2.5
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Дүн	43,638.5	41,106.6	2,531.9

Эх сурвалж: Аудитын судалгаа

ОНХСан 36,565.0 мянган төгрөгийн, Эмийн эргэлтийн сан 4,544.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

- Аудитын илрүүлэлт: Өглөг данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,794,362.6 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 282,855.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	837,887.7	837,887.7	0
Хуримтлагдсан үр дүн	3,673,619.5	3,956,475.0	282,855.5
Өмнөх үеийн үр дүн	3,137,103.3	2,796,093.4	(341,009.9)
Тайлант үеийн үр дүн	(348,471.1)	288,478.2	636,949.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	884,987.3	871,903.4	(13,083.9)
Дүн	4,511,507.2	4,794,362.6	282,855.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,637.4 сая төгрөгөөр, төсвийн зарлагыг 2,941.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тодотголоор 304.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2,941.8 сая төгрөгөөр баталсан байна. Нийт зардлын 1,995.7 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 769.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 100.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 76.7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 2,635.3 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд: сумын орон нутгийн төсвөөс 1,842.9 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 737.9 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 54.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 32.4 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын эргэн төлөлтийн орлого, 22.1 сая төгрөг нь ОНХСангийн орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,941.7 сая төгрөг буюу 84.1 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2023 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 73 дугаар тогтоолоор Ногооннуур сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 923.1 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын 2023 оны “2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 78 дугаар тодотголоор 923.1 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Сумын ИТХ-ын 2024 оны А/02 дугаар тогтоолоор 2024 орлогын төлөвлөгөөг 379.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,302.2 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 1,323.9 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 21.7 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	1,295.0	1,308.2	13.2	101.0
II.Татварын бус орлого	7.2	15.7	8.5	217.7
Нийт дүн	1,302.2	1,323.9	21.7	101.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн татварын орлогод 1,295.0 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 1,308.2 сая төгрөгийн орлого оруулж 13.2 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар давсан. Татварын бус орлогод 7.2 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 15.7 сая төгрөг оруулан 8.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд үйл ажиллагааны орлогын албан татварыг 86.5 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 11.7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсан орлогыг 0.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжыг 0.2 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 2.9 сая төгрөгөөр, хүүгийн орлогыг 0.5 сая төгрөгөөр давж, төлөвлөгдөөгүй малын тоо, толгойн албан татвараас 9.7 сая төгрөг, төсөвт газрын өөрийн орлогоос 5.0 сая төгрөгийн орлого оруулсан нь төлөвлөгөөний биелэлтэд голлон нөлөөлсөн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 39.3 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 0.9 сая төгрөгөөр, бууны албан татвар 2.1 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 6.9 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5.0 сая төгрөгөөр, ойгоос мод түлээ мод бэлтгэж ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, агнуурын нөөцийн төлбөр 43.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 73.9 сая төгрөг олгосон байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 86.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 1,308.2 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж, оны эцэст 164.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн зарлагын гүйцэтгэл:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	ИТХУрал	317.5	243.3	-74.2
2	ЗДТГазар	1,423.9	1,374.9	-49.0
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	76.4	76.4	-
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	13.5	13.5	-
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	17.6	17.6	-
6	Ерөнхий боловсролын 4-р сургууль	17.5	17.5	-
7	Хүүхдийн цэцэрлэг	33.9	25.9	-8.0
8	Хүүхдийн цэцэрлэг-2	47.8	37.3	-10.4
9	Соёлын төв	8.3	7.8	-0.5
10	Эрүүл мэндийн төв	28.8	28.8	-
11	ОНХСан	856.6	631.7	-225.0
12	СХСан	100.0	0.4	-99.6
	Нийт дүн	2,941.8	2,475.1	-466.7

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан төлөвлөлттэй холбоотой ба ОНХС-гийн төсвийн гүйцэтгэлд 7 төсөл хөтөлбөрийн ажил дутуу хийгдсэн нь нөлөөлсөн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд 12.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнд: дээд шатны төсвийн захирагчаас нийт 6.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 6.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч тээвэр шатахууны зардалд 3.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 9.0 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/55 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,732.5 сая төгрөгөөс 25.9 хувиар буюу 34.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх шатны материаллаг байдлыг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,311.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 34.7 сая төгрөгөөр аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын БӨА-2025/002/НА-СТА-ТТЗ

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 8.1 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 229.4 сая төгрөгийн 24 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 99.8 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

- *Аудитын илрүүлэлт: Шилэн данстай холбоотой зөрчил гараагүй байна.*

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа зөрчилтэй суудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна. Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй боловч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар бүх сумын Засаг дарга нарт малын татварын төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” зөвлөмж өгсөн ба малын татварын орлогыг сумын ИТХ-аар батлуулж ажиллаагүй байна.

Ногооннуур сумын [Хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах 97.6 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.](#)

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1. Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр сургууль, хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Сумын ЗДТГазрын санхүүгийн тайланд “хязгаарлалтай” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 540.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 140.1 сая төгрөгийн алдааг залруулж, 6.7 сая төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 178.4 сая төгрөгийн 7 албан шаардлага, 215.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Чихтэй багийн ерөнхий боловсролын сургууль, Ховд багийн ерөнхий боловсролын сургууль, Улаанчулуун багийн ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж үзсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа бусад байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 1,845.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 128.2 сая төгрөгийн алдааг залруулж, 3.4 сая төгрөгийн төлбөрийн 3 акт тогтоож, 54.0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1,660.0 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4: Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Захирагчийн алба	7	188.8	2	62.4	1	6.1	3	31.2	1	89.1
2	ИТХурал	6	141.6	2	77.7	1	0.6	2	13.2	1	50.1
3	ОНХС	3	170.5					2	134.0	1	36.5
4	ХХС	1	39.7							1	39.7
Орон нутгийн байгууллагын дүн		17	540.6	4	140.1	2	6.7	7	178.4	4	215.4
1	ЕБ-ын 1-р сургууль	3	2.5			2	2.5			1	
2	ЕБ-ын Чихтэй багийн сургууль	1	0.0							1	
3	ЕБ-ын Ховд багийн сургууль	2	0.9							2	0.9

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	ЕБ-ын Улаанчулуу багийн сургууль	2	0.1	1	0.1					1	
5	Хүүхдийн цэцэрлэг	3	105.7	1	101.6			1	4.1	1	
6	Хүүхдийн цэцэрлэг-2	9	1,356.7	4	26.5	1	0.9	1	4.1	3	1,325.2
7	Соёлын төв	2	55.8					1	45.8	1	10.0
8	Эрүүл мэндийн төв	4	323.9							4	323.9
Бусад байгууллагын дүн		26	1,845.6	6	128.2	3	3.4	3	54.0	14	1,660.0
Нийт дүн		43	2.386.2	10	268.3	5	10.1	10	232.4	18	1,875.4

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулга хийгдээгүй, зөрчил илрээгүй.

Аудитын дүнгээр Сумын Засаг дарга, Санхүүгийн албад дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1.Сумын төсөвт байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 10.1 сая төгрөгийн төлбөрийн 5 актыг хугацаанд нь барагдуулах, 232.4 мянган төгрөгийн 10 албан шаардлага, 1,875.4 мянган төгрөгийн 18 зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ-ийн харьяа байгууллагуудад өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнах	1						1					
Дүн	1						1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								